

Олон Улсын Зуслангуудын Холбооны 2014 оны жилийн тайлан

Гарчиг

1. Их Хурал
2. 2014 оны Олон Улсын Зуслангуудын Холбооны их хурал
3. Ази Номхон далайн зуслангууд
4. Улсын элч нарын тухай
5. Хөтөлбөр хариуцсан хороо
6. ICDC буюу захирлуудын сургалт
7. Гишүүнчлэл
8. Санхүүгийн тайлан
9. Удирдлагуудын тухай
10. 2014 оны ОУЗХ-ны их хурал

Олон Улсын Зуслангуудын Холбоо нь өөрсдийн хүсэл сонирхол, мэдлэг чадвар, зусланд оруулсан хувь нэмрээсээ бусадтайгаа хуваалцахаар нэгдсэн олон улсын зуслангийн мэргэжилтнүүдийн холбоо юм.

Бид өөр өөр хэл соёл, зан заншилтай улс орнуудын “Гадна орчинд явуулдаг сургалтуудыг” нэг тавцанд цуглуулан, өөрчлөлт шинэчлэлтийг авчирах хүсэл зорилготой билээ.



ОУЗХ-ны зорилго

- Өөр өөр орнуудын хувь хүмүүс, зуслангууд, гадна орчинд сургалт явуулдаг газрууд болон албан байгууллагууд мэдээ мэдээллээ өөр хоорондоо оновчтой дамжуулахад нь туслах
- Хоёр талын болон олон талт солилцоог хөхүүлэн дэмжих
- Зуслан болон гадна орчны сургалтуудаар дамжуулан хүүхдийн манлайлах чадварыг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах, улс орны аж амьдралтай танилцахад нь түлхэц, урам зориг өгөх
- Бүсийн болон үндэсний зуслангуудын холбооны үйл ажиллагааг дэмжих

Ерөнхийлөгчийн өмнөх үг



Valery Koesten

ОУЗХ нь олон оронд хүрч ажиллан, хурдацтайгаар өсөн дэвжиж буй эрч хүч, шинэ санаачлагаар дүүрэн байгууллага юм. Энэ жилийн хувьд хэд хэдэн шинэ бүтээн байгуулалт, хамтын ажиллагаа, түншлэл хийсэн сайхан жил боллоо.

2011 онд засаг захиргаа болон гишүүнчлэлийн бүтцэд оруулсан өөрчлөлтүүдийн ачаар нийгэм дэхь олон хүмүүсийг сайн дураараа бидний арга хэмжээнд оролцох боломжийг нь нээж өгсөн. Хурдацтай хийгдэж буй энэ бүх шинэчлэл, дэвшил нь бидний хөгжиж байгаагийн шинж тэмдэг юм.



Бид одоогийн байдлаар зуслангийн хөдөлгөөнийг мэддэггүй улс орнуудад хүрч ажиллаж байна. ОУЗХ нь Биалецки/АНУ/ болон Файн /Канад/ нарын удирдлаган доор төсөл зохион байгуулах, бусад орны хүмүүстэй мэдлэгээсээ хуваалцах, мөн зусланд дадлагажигчидад мэргэжлийн хэллэг зааж өгөх, хэрэгтэй зүйлсээр нь хангах зэрэг бүрэн эрхт судалгааны багийг байгуулсан.

2012 оны 5-р сард Монгол Улсын “Найрамдал” ОУЗ “Ирээдүйн бүлгийн удирдагч” сэдэвтэй сургалтыг эх орондоо зохион байгуулсан. Энэхүү сургалтанд дурдагдсан аргачлалуудыг Нигер улс нь өөрсдийн зуслангуудын хөгжилд хэрэгжүүлж байна.

Мөн ОУЗХ нь өөрсдийн Билл Боукер Тэтгэлэгийн сангаараа дамжуулан Нигерийн Ибаданы ойролцоо орших “Ланлэйт Инициатив”-дахь “Ирээдүйн бүлгийн удирдагч” төслийг санхүүжүүлсэн.



ОУЗХ нь захирлуудын сургалтыг дэлхийн хэд хэдэн орнуудад байнгын давтамжтайгаар явуулдаг ба хамгийн сүүлийнх нь л гэхэд Малайз болон Австрали орнуудад болж өнгөрсөн байна. Мөн удахгүй Туркийн Анталя хотноо болох ОУЗХ-ны Их Хурлын үеэр 3 өөр хэл дээр 3 өөр сургалт явуулахаар төлөвлөж байна.

Бид Туркийн Анталя-д болох 2014 оны ОУЗХ-ны Их Хурлыг сэтгэл догдлон хүлээж байна. Төлөөлөн удирдах зөвлөл Их Хурлын байранд уулзах болно.

2013 онд, ОУЗХ нь ТУЗ-ийн хурлаа АНУ-гийн Атланта мужид ОУЗХ-ны Зуслангийн Аялал болон Америкийн Зуслангийн Холбооны хуралтай хоршин зохион байгуулсан. Хурлын дэлгэрэнгүйг энд оруулсан байгаа. Мөн түүнчлэн, 11 сард Австралийн Сидней хотноо зохион байгуулагдсан Ази Номхон далайн бүсийн зуслангуудын Их Хуралд бараг бүх ТУЗ-ийн гишүүд оролцож чадсан.

ТУЗ, байнгын хороод, захирлуудын сургалтын багшлах бүрэлдэхүүн болон бусад сайн дурын ажилчид бүгд ямар ч цалин хөлсгүйгээр, зөвхөн хийж байгаа зүйлээсээ сэтгэл ханамж аван хүсэл зорилго нэгтэйгээр ажилладаг билээ. Иймд би хувиасаа маш их талархаж байна. Бид бүгд ашиг хүртэгчид нь юм шүү.

Их Хурал

ОУЗХ-ны Их Хурал 3 жил тутамд нэг удаа болдог билээ. Бид энэ удаа 2014 оны 10-р сард газар дундын тэнгисийн эрэгт буюу Туркийн Анталя хотноо уулзах гэж байна. Энэ гайхалтай арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг тайланд тусгасан байгаа.





ОУЗХ-ны Их Хурал нь зуслантай холбоотой бүх хүмүүсийн цуглан, эргэн нэгдэх боломжийг нь үргэлж нээж өгдөг. Энэхүү Их Хурал нь жил ирэх тусам улам л өргөжин дэвжиж байгаа юм. Одооноос эхлэн Их хурал болгоны үеэр Судалгааны форум болох ба үүгээр дамжуулан, зуслан, гадна орчны сургалт, болон залуусын хөгжлийн талаар судалгаа хийсэн судлаачид үр дүнгээ тайлагнан, бусадтайгаа хуваалцах боломжтой болж байгаа юм. Их Хурлын өмнө болон дараа хэд хэдэн чухал уулзалтууд болон ОУЗХ-ноос зохион байгуулдаг “Захирлуудын сургалт” зэрэг нэмэлт сургалтууд болдог.

Хурлын үеэр болдог шинэ шинэ хөтөлбөрүүд нь дэлхийн өнцөг булан бүрээс толилуулагддаг ба олон улсын зусланд амрагчид болон зусланг ажлуулагчидыг холбож өгөх гүүр нь болж өгдөг билээ.

Одоогийн байдлаар ОУЗХ-нд идэвхтэй байдаг 60 гаруй орны 500 гаруй оролцогчид ирэхээр зэхээд байна. Дараагийн Их Хурлыг зохион байгуулах улсыг тендер зарлан сонгоход бүтэн 6 жил зарцуулагддаг билээ. ОУЗХ-ны 2017 оны Их Хурлыг зохион байгуулах үйл явц амжилттайгаар үргэлжилж байгаа ба 2014 оны Их Хурлын үеэр зарлахад бэлэн болсон байна гэж тооцож байна.

ОУЗХ-ны 2014 оны Их Хурал

“Энх тайвны төлөө зусланд амарцгаая” уриатай ОУЗХ-ны 2014 оны Их Хурлыг Туркийн зуслангуудын холбоо болон Туркийн “Ирээдүйн одод” зуслан хамтран зохион байгуулах гэж байгаа билээ. 2014 оны Их Хурлаар дараах зорилтуудыг тавиад байна:

- Илүү олон залуучуудыг оролцуулах
- Бизнес сэтгэлгээ ашиглан зуслангуудыг сайжруулах
- Хурлын үеэр техник технологийг бүрэн ашиглах

Их Хурлын сурталчилгаа



Фахреттин Гозет өнгөрсөн 3-н жилийн турш Их Хурлаа сурталчилахад маш их хүч хөдөлмөр зарцуулсан. Илүү олон хүмүүст хүрэхийн тулд Фахри дараах орнуудаар ОУЗХ болон Их Хурлаа төлөөлөн айлчилсан: ОХУ-6 удаа, Австрали, БНХАУ-2 удаа, АНУ, Швейцарь, Венесуэл. Мөн түүнчлэн Монгол, Грек, Украин зэрэг орнуудаар зочилохоор зэхэж байна.

Их Хуралтай холбоотой бусад тодруулгууд:

Захирлуудын сургалт – Орос, Англи, Турк хэл дээр, Судалгааны Форум, хэд хэдэн хэл дээр тохируулсан вебсайт болон олон нийттэй харилцах хэрэгслүүд

ОУЗХ-ны 2014 оны Их Хурал “Энх тайвны төлөө зусланд амарцгаая” уриатайгаар дэлхий нийтийг хүлээн авахад бэлэн болоод байна.

Ази Номхон Далайн Зуслангуудын Холбоо

10-н жилийн өмнө буюу 2003 онд Австрали улсад, Азийн орнуудын зуслэгийн удирдагч нар уулзан Ази дахь зуслангуудыг хөгжүүлэх, хоорондын харилцаа холбоогоо ихэсгэх үүднээс ОУЗХ-ны харьяа Азийн орнуудын Зуслангуудын холбоог байгуулахаар тохиролцсон юм. Тэнд цугласан байсан хүмүүс саналаа нэгтгэн, анхны Азийн Зуслангийн Холбооны Их Хурлыг Монгол улсын “Найрамдал” ОУХЗ-д 2004 оны 7-р сард хийхээр шийдсэн билээ. Дараа нь, 2006 оны 8-р сард Малайзын Перакд болсон Азийн Зуслангийн Холбооны 2 дахь Их Хурлаар нэрээ “Ази Номхон Далайн Зуслангуудын Холбоо” /АНДЗХ/ болгон өөрчилж, ОХУ, Австрали болон Туркменистан Улсуудыг урин нэгтгэж, мөн Ази, Номхон далайн бүс нутгийн нэгдэх сонирхолтой бүх улс орнуудын гишүүнчлэлийг нээлттэй болгож өгсөн юм.

ОУЗХ-нд сайн дурын гишүүнчлэл бий болсонтой холбогдуулан, АНДЗХ-д нэгдэх сонирхолтой хүмүүст давхар ОУЗХ-ны сайн дурын гишүүнчлэл санал болгож байгаа билээ. Харин Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудад буй ОУЗХ-ны сайн дурын болон жинхэнэ гишүүд давхар АНДЗХ-ны гишүүн гэж тооцогдоно. АНДЗХ-ны хурал нь 3 жил тутамд нэг удаа буюу ОУЗХ-ны Их Хурлаас нэг жилийн өмнө явагддаг. АНДЗХ-ны хурлын үеэр ерөнхий хуралдаан хийж дараагийн хурал хүртэл алба хаших Удирдлагын хорооны хүмүүсийг томилдог.

11 сард, ОУЗХ нь АНДЗХ-ны Ази, Номхой далай болон дэлхийн улс орны зуслангуудад 10 жилийн турш оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, “Эрвээхэй” шагналыг олгосон.



Ази, Номхон далайн Зуслангуудын Холбооны 5 дахь удаагийн Их Хурал, Австралийн Сидней хот, 2013 он

2013 оны 10-р сард АНДЗХ-ны 5 дахь удаагийн их хурал Австралийн Сидней хотноо амжилттай болж өнгөрсөн билээ. Их Хурал, 2000 оны Олимпын наадам болсон Сидней Олимпын хүрээлэнд зохиогдсон. 4 өдөр болж өнгөрсөн энэхүү үйл ажиллагаанд 360 гаруй хүн оролцсон ба тэдгээрээс 120 нь 14 өөр орны хүмүүс байсан юм. Үүгээрээ энэ хурал нь Австралид болж байсан зуслангийн хурлуудас хамгийн том нь болсон билээ.

Хурал Нью Саут Вэйлс дахь хүчтэй гал түймэртэй давхацсан учираас оролцогчид алдарт Блю Маунтэйнс руу явах аяллаа хийж чадаагүй юм. Гэсэн ч сонирхолтой, хөгжөөнтэй олон аялал болон хөтөлбөрөөс гадуур үйл ажиллагаанууд хурлын үед, өмнө болон дараа зохион байгуулагдсан. Мөн олон улсын түвшний захирлуудын сургалтыг ирээдүйн зуслангийн захирлууд болон захирлуудын сургалтыг цаашид явуулах шинэ сургагч нарт зориулан явуулсан.

АНДЗХ-ны Их Хурлын үед болсон АНДЗХ-ны Ерөнхий хуралдаанаар дараагийн улирлын албан тушаалтнуудаа сонгосон ба, 6 дахь удаагийн АНДЗХ-ны Их Хурлыг 2016 оны 10-р сард Японы Токио хотноо Японы Зуслангуудын Холбоо зохион байгуулахаар болсноо албан ёсоор мэдэгдсэн юм. 2016 оны Их Хурлын үеэр Японы Зуслангуудын Холбооны 50 жилийн ой тохиох учир баярыг нь хамтдаа тэмдэглэх сайхан боломж бидэнд бүрдэж байна.

Улсын элч нар

2011 оноос эхлэн элч нар нь удирдлагуудын нэг болсон бөгөөд, тэд өөрсдийн орны ОУЗХ-ны гишүүдийн оролцоо болон тоог нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм. Улс орон бүр өөрсдийн элчээ сонгох буюу томилохдоо өөр өөр арга механизм ашиглаж байна.

Элч төлөөлөгчтэй улс орнууд	
Хэрэв танай оронд элч байхгүй бол элчтэй болохыг бодоорой	
Австрали	Жон Вүүдс
Канад	Габриела Рейл
Колумб	Луи Энрике Гарсиа
Англи	Клив Клиффорд
Герман	Жан Виет
Хонг Конг	Санни Хо
Ирланд	Терри Дигнан
Япон	Шин Такахаши
Мексик	Генаро Ортиз Тирадо
Монгол	Иван Жаргалсайхан
ОХУ	Алексей Андреев
Серб	Марко Джёржевич
Турк	Утку Топраксевен
Украин	Олександр Кашляков
АНУ	Гин Повелл
Венесуэл	Гонзало Велоз

Элч нар дараах үүргүүдийг биелүүлнэ:

- Өөрийн орныхоо ОУЗХ-ны жинхэнэ гишүүдийг нэмэгдүүлэх
- Үндэсний болон Олон Улсын хэмжээнд зусланд амрагч хүүхдүүд болон зуслангийн багш нарын солилцоо хийх зэргээр гишүүдийн холбоо харилцаанд хувь нэмрээ оруулах
 - ОУЗХ-нд өөрийн орныхоо мэдээ мэдээллийг байнгын хүргэх
 - Өөрийн орны зуслангууд болон гадна орчин дахь сургалтуудын тухай мэдээлэл цуглуулах
 - Олон улсын зусланд амрах болон ОУЗХ-ны хөтөлбөрүүдийн тухай мэдээлэл түгээх
 - ОУЗ-ын их хурал дээр ОУЗХ-ны Ерөнхий Ассамблейгийн гишүүн болж ажиллах
 - Хэрэгтэй үед өөрийн улс оронд дүүргийн зохицуулагчийг хамгаалах
 - ОУЗХ хүссэн тохиолдолд өөр бусад зүйлсээр туслах



Хөтөлбөр хариуцсан хороо

Одоогийн байдлаар хөтөлбөр хариуцсан хороо маань 4 том хөтөлбөр дээр ажилж байна.

1. Захирлуудын сургалт – Австрали 2013

Австралийн Сидней хот дахь Баден Повелл Скаутын Зуслан

Энэхүү олон улсын сургалт нь 5 дахь Ази Номхон Далайн Зуслангуудын холбооны Их Хурал болохын өмнөхөн Сиднейн Скаутын зусланд болж өнгөрсөн билээ. Сургалтыг АНДЗХ-ны Их Хурал болон Австралийн зуслангуудын холбоо хамтран зохион байгуулсан юм. Нийт 5 орны 22 оролцогч, 4 дадлагажигчид цугласан. Ахлах удирдагчаар Захирлуудын сургалтын зохицуулагч Конни Котеллиэр, мөн удирдагч багшаар Андрю Макгүкиан, Пол Колагюри болон туслах багшаар Шима Али, Мари Фютрилл, Ребекка Фокс нар тус тус байсан.

Дараагийн сургалтууд:

Туркийн Анталя хот

Захирлуудын сургалт ОУЗХ 2014

10-р сарын 19-23 Англи, Турк, Орос хэл дээр /сургагч бэлтгэх курс мөн давхар явагдана/

Захирлуудын сургалт Малайзын Жохор хот 2014

8-р сарын 25-28

Мөн Венесуэлийн Каракас хот болон БНХАУ-ын Бээжин хотноо зохиогдохоор тус тус яригдаж байна



ОУЗХ-ны 2011 оны Их хурлын үеийн захирлуудын сургалтын багш нар – Горд Каплан /АНУ/, Жуан Марио Гутерез /Колумб/, Кони Котелиер /АНУ/, Андрю Макиан /Австрали/



АНДЗХ-ны 2013 оны Их Хурлын үеийн захирлуудын сургалт



2013 онд Мексикт болсон захирлуудын сургалт



2013 онд Малайзд болсон захирлуудын сургалт

2. ОУЗХ-ны шагнал гардуулалт

ОУЗХ-ны “Эрвээхэй” шагналыг 2 байгууллагад олгосон байна. Үүнд:

АНДЗХ - Ази Номхон Далайн Зуслангуудын Холбоо

2003 онд байгуулагдсан цагаасаа хойш Ази Номхон Далайн Зуслангуудын Холбоо нь өөрсдийн бүс нутаг дахь зуслангийн мэргэжилтнүүдийн холбоог бататгаж өгч, ОУЗХ-ны зорилго зорилтууд болон үнэлэмжүүдийг мэдээлэл харилцаа, хөгжил дэвшил, солилцооны хөтөлбөрүүдээрээ дамжуулан бусдад хүргэсэн билээ. Одоогийн байдлаар АНДЗХ-ны 5-н Их Хурал болж өнгөрсөн ба хамгийн сүүлийнх нь Австралийн Сндней хотноо зохиогдсон юм.

Гадна орчны Зөвлөл

Нью Саут Вейлсийн/НСВ/ Гадна орчны Сургалтын Зөвлөл /ГОСЗ/ нь төр болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, НСВ-ийн гадна орчинд амрагчдын төлөөлөл болсон, мөн гадна орчны сургалт явуулахад нөөц бололцоогоор хангаж өгдөг байгууллага юм. Австрали болон Нью Саут Вейлсдээ ГОСЗ нь салбарынхаа шилдэг нь билээ. Хамгийн сүүлд гэхэд ГОСЗ нь АНДЗХ-ны 5 дахь Их Хурлын томоохон хамтрагч нь байсан. ГОСЗ нь 1984 онд салбараа төлөөлөх, сурталчлах зорилготойгоор байгуулагдсан ашгийн төлөө бус байгууллага юм.

3. Судалгааны баг

Деб Биалецки /АНУ/ - ахлагч
Стефен Файн Канад – ахлагч
Луй Гарсий де Бригард Колумб
Карла Хендэрсон АНУ
Тайто Окамура Япон
Утку Топраксевен Турк
Түлшиг Түвшин Монгол
Йан Виллиамс Австрали

ОУЗХ нь 2013 онд Судалгааны Хороогоо байгуулсан. Деб Биалецки, Стефен Файн нараар ахлуулсан энэхүү хороо нь цаашид Их Хурал болгоны үеэр Судалгааны форумтаа толилуулахаар болж байгаа билээ. Судалгаанаас гарсан онц сонирхолтой, үнэ цэнэ бүхий үр дүнгүүдээсээ улс орнуудын зуслангийн удирдлага, ажилтнуудтай хуваалцаж, тэдгээр хүмүүс нь эргээд цаашаагаа зуслангийн хөдөлгөөнийг сурталчилж, цаашдын стратегийн хөрөнгө оруулагчидыг татна хэмээн найдаж байна.

Турк улсад болох Их Хурлын үеэр зохион байгуулах Судалгааны Форумаараа бид “Дэлхийн иргэншлэл 2” төслийн үр дүнг танилцуулах болно.

Судалгааны баг одоогоор АНУ-ын эрдэмтэн Гвин Повелийн хамтаар өөрсдийн гишүүдийн ерөнхий мэдээлэл болон тэдэнд юу хэрэгтэй байдгийг харуулах судалгааныхаа загварыг гаргаж байна.

Судалгааны Форум нь 2014 онд Турк улсад болох ОУЗХ-ны Их Хурлын нэг хэсэг болон зохиогдоно. Одоогийн байдлаар судалгааны үр дүнгүүдээ цуглуулан нэгтгэх үйл ажиллагаандаа орох гэж байна/Бүх явуулсан үр дүнгүүдийг судалгааны баг хянан оруулна/. Нэгдсэн тайлангаа PDF file болгон ОУЗХ-ны вебсайтан дээрээ байрлуулах болно.

Мөн Судалгааны баг нь ОУЗХ дотроо аль аль хэсгүүдэд судалгаа хийх хэрэгтэй вэ гэдгийг харуулсан төслийн ажлаа бичээд эхэлсэн байна. Судалгааны вебсайт нь зуслангийн тал дээр хийгдсэн олон улсын болон үндэсний хэмжээний судалгаа, шинэ санаа, төслүүдийг нэгтгэн хүмүүст таниулах зорилготой хийгдээд байна. Цаашид ОУЗХ-ны гишүүдийн хамтаар хийх судалгааны жагсаалт гарж ирсээр байх билээ.

4. Тусгай хөтөлбөрт сургалтууд

ОУЗХ нь орон нутгийн холбоод болон бүс нутгийн төслүүдийг дэмжих бүрэн бололцоотой болсон билээ. 4-р сард ОУЗХ Оросын Самара дахь зуслангуудын холбоонд удирдагчийн сургалт, Твер хотноо Олон Улсын зуслангуудын хүмүүжүүлэгч багш нарын сургалт, Нигерийн Ланлатед “Дэлхийн Удирдагчид” сургалтыг тус тус зохион байгуулсан. ОУЗХ-ны хурлын өмнө АНУ-гийн Зуслангийн холбооны зуслангуудаар хийдэг аялал бидний байнгын онцлох зүйлсийн нэг юм. Мөн, энэ жил Австралийн Сидней хотноо болсон АНДЗХ-ны Их Хурлын үеэр ОУЗХ удирдагчийн сургалт зохион байгуулсан.



“Үндэстний зүрх” холбооны зуслангийн захирлуудын сургалтын үеэр – ОХУ, Самар хот- 2013 оны 4-р сар



Сургуулиудаар зочилсон нь – ОХУ, Самар хот- 2013 оны 4-р сар



Дэлхийн удирдагчид сургалт- Нигер, Ланлате хот – 2013 оны 12-р сар



Захирлуудын сургалт – ОХУ, Твер хот- 2013 оны 4-р сар



Жон Жоргенсон, Жилл Дандас, Женни Боукер, Жефф Брэдшоу – АНДЗХ-ны 2013 оны Их Хурал- Австрали, Сидней хот – 11-р сар



Жилл Дандас- ОУЗХ-ны санхүүгийн ажилтан, Карол Чели – ОУЗХ-ны мэдээлэл харилцаа, Кони Котеллиер- Захирлуудын сургалтыг зохицуулагч нар – 2013 оны АНДЗХ-ны Их хуралын үеэр- Австрали , Сидней хот

Гишүүнчлэл

2013 онд Австралийн Зуслангийн Холбооны хамтын ажиллагааны үр дүнд ОУЗХ-ны гишүүнчлэл ихээр нэмэгдсэн билээ:

Зуслалуудын холбоо	13
Зуслангууд	342
Байгууллагууд	25
Хувь хүмүүс	133
Сайн дурын	1671
Нийт	2204



2012 оноос эхлэн шинээр үүссэн ОУЗХ-ны сайн дурын гишүүд байнгын цахим харилцаа холбоотой байх бололцоотой болсон юм. Жинхэнэ гишүүнчлэлтэй хувь хүн, зуслан, байгууллага, холбоодууд хямдралтай үнээр Их Хуралл оролцох, санал өгөх эрх, албан тушаалд өрсөлдөх, гишүүнчлэлийн сертификат авах гээд маш олон давуу талуудтай.

Түүнчлэн, зуслан, байгууллага, холбоодууд нь ОУЗХ-ны вебсайтын тусгай линкээр орон ОУЗХ-ны логог хэрэглэх бололцоотой ба Америкийн Зуслангуудын холбоо, АНДЗХ-ноос зарим хөнгөлөлтийг авч болох юм. ОУЗХ-ны вебсайтаар дамжуулан гишүүн болох, гишүүнчлэлээ солих, сайн дурын гишүүнд элсэх зэрэгийг хийхэд илүү хялбар болсон.

Зуслангуудын Холбоодын харилцаа холбоо:

Дэлхий дээрх зуслангууд болон залуусыг хөгжүүлдэг байгууллагуудын удирдагч нарт хүрч ажиллахын тулд ОУЗХ-ны ТУЗ үндэсний болон бүсийн байгууллагуудтай шууд харилцаа холбоотой ажилласаар байгаа билээ.

ОУЗХ нь 2013 оны 2-р сард Америкийн зуслангийн холбоотой байгуулсан хамтын гэрээгээ сунгаснаар АЗХ-ны Боловсролын Хамтрагч болсон юм. Үүний үр дүнд ОУЗХ нь АЗХ-ны мөн Бизнес хамтрагч нь болсон ба ОУЗХ-ны Их Хурлын үеэр хийх сургалтуудаа үргэлжлүүлэх эрхтэй болсон юм.

Австралийн зуслангийн холбооны хамтын ажиллагаагаар дамжуулан АвстЗХ өөрсдийн жинхэнэ гишүүдэд ОУЗХ-ны гишүүнчлэлийг 2 дахь жилдээ амжилттай олгож байна. Мөн бусад холбоодтой хамтран ашигтай ажиллах загварыг 2014 онд үргэлжлүүлэн хэлэлцэж байна.

ОУЗХ-ны 2014 оны Их Хурлын үеэр зуслангийн холбоодын дарга, удирдагч нар хуран чуулж, асуудал, санал хүсэл зэргээ хуваалцах болно.

ОУЗХ-ны гишүүн улсууд

2013 оны сүүл гэхэд нийт 2204 жинхэнэ болон сайн дурын гишүүд дараах орнуудад байна:

1) Австрали	18) Франц	35) Малайз	52) Өмнөд Африк
2) Азербайжан	19) Жеоржиа	36) Мексик	53) Өмнөд Солонгос
3) Бангладеш	20) Герман	37) Монгол	54) Испани
4) Бермуд	21) Гана	38) Мянмар	55) Швед
5) Болив	22) Грек	39) Шинэ Зеланд	56) Швейцарь
6) Босния Герцеговина	23) Хонг Конг	40) Нигер	57) Тайван
7) Бразил	24) Унгар	41) Пакистан	58) Тайланд
8) Камбож	25) Исланд	42) Палестин	59) Турк
9) Камерун	26) Энэтхэг	43) Панама	60) Уганда
10) Канад	27) Индонези	44) Филиппин	61) Их Британи
11) БНХАУ	28) Ирланд	45) Польша	62) Украин
12) Колумб	29) Итали	46) Бенин	63) АНУ
13) Коста Рика	30) Япон	47) Румын	64) Венесуэл
14) Хорват	31) Казакстан	48) ОХУ	65) Зимбаб
15) Ципрус	32) Кеня	49) Серби	
16) Доминикан	33) Латви	50) Сиера Леон	
17) Эквадор	34) Либер	51) Сингапур	

2013 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

Орлого

Захирлуудын сургалтын орлого

8072.49 Тэмдэглэл 1-г хар

ОУЗХ-ны аялал-АЗХ-ны уулзалт		8112.20	Тэмдэглэл 2-г хар
Гишүүнчлэлийн төлбөр		8648.01	Тэмдэглэл 3-г хар
Банкны хүү	2.08		
Нийт орлого		24834.78	
Зардал			
Банкны шимтгэл	91.00		
АНДЗХ-ны захиргааны зардал		600.00	Тэмдэглэл 4-г хар
ТУЗ-ийн хурлын хоолны зардал		442.27	
ТУЗ-ийн аяллын зардал		2300.00	Тэмдэглэл 5-г хар
Сонгууль		170.85	Тэмдэглэл 6-г хар
Хүлээн зөвшөөрөл		815.86	
Вебсайт	10600.00		
Захирлуудын сургалт		3877.10	Тэмдэглэл 1-г хар
ОУЗХ-ны аялал-АЗХ-ны уулзалтын зардал		7744.40	Тэмдэглэл 2-г хар
Даатгал		1836.00	
Бусад зардал		160.00	Тэмдэглэл 7-г хар
Захиргаа, аж ахуйн зардал		170.30	
Нийт зардал		28807.78	
Нийт ашиг		-3973.00	

2013 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлангийн тодруулга

Тэмдэглэл 1:	<u>Захирлуудын сургалт</u> Захирлуудын сургалт зохион байгуулсан орон бүр гарсан зардлынхаа 10-аас багагүй хувийг ОУЗХ-д тушаах үүрэгтэй. 2013 онд Мексик /2012 оны сургалт/ болон Австрали /2013 оны сургалт/ улсуудаас мөнгө хүлээн авсан. 2013 онд Австралид болсон сургалтыг зохион байгуулагчийн тээвэр болон даатгалтай холбоотой зардлыг нь ОУЗХ гаргасан. Эдгээр зардлын дараах цэвэр орлого 4195.39 ам.доллар байна.
Тэмдэглэл 2:	<u>АЗХ-ны аялал</u> ОУЗХ-ны номтой холбоотой гүйлгээнүүд энэхүү аялалын үеэр гарсан. Аяллын үеэр зохиогдсон арга хэмжээ болон хандивлагч нарын ачаар нийт 367.80 ам.доллар олсон байна.
Тэмдэглэл 3:	<u>Гишүүнчлэлийн төлбөр</u> ОУЗХ нь гишүүнчлэлийн төлбөрийг тооцохдоо хуримтлалын зардлыг ашигладаг. Төлбөр нь бүтэн 3-н жилээр хийгддэг учир төлбөрийг 3-н жилд тэнцүү хуваан тооцдог. 2013 онд тусгагдсан зардал нь дараах байдлаар задрана: 2011 онд авсан төлбөрийн 2013 онд ноогдох хэсэг нь 2012 онд авсан төлбөрийн 2013 онд ноогдох хэсэг 2013 онд авсан төлбөрийн гуравны нэг
Тэмдэглэл 4:	<u>АНДЗХ-ны захиргааны зардал</u> Гэрээнд заасны дагуу ОУЗХ нь захиргааны зардал болгон 300 ам.долларыг АНДЗХ-нд байршуулдаг. 2012 онд үүнийг хийлгүй өнгөрөөсөн учир 2013 онд 2013 болон 2013 оны мөнгийг хамтад нь шилжүүлсэн. Ердийн үед бол 300 ам.доллар гэж бүртгэгддэг.
Тэмдэглэл 5:	<u>ТУЗ-ийн аяллын зардал</u> ТУЗ-ийн гэрээнд заасны дагуу, ойн баяр болон том арга хэмжээ зохион байгуулж буй гишүүн байгууллагуудад уригдсан ТУЗ-ийн гишүүдэд, цаад талаасаа зардлыг нь дааж чадахгүй тохиолдолд, зардлыг нь ОУЗХ зүгээс гаргаж өгдөг. 2013 онд Хонг Конг руу явсан 2 хүний зардлыг даасан.
Тэмдэглэл 6:	<u>Сонгууль</u> 2013 онд дараагийн ерөнхийлөгчийн сонгууль явагдсан. Сонгуультай холбоотойгоор хуралдсан Гүйцэтгэх зөвлөлийн хурал болон онлайн-аар сонгууль явуулахад ашигласан софтверийн зардал тус тус орсон байна.
Тэмдэглэл 7:	<u>Бусад зардал</u> ОУЗХ-ны бүх файлыг хадгалах төхөөрөмж буюу хард драйв худалдан авсан зардлыг энд тусгасан болно.

Нийтэд нь дүгнэхэд:

Хэдийгээр бид энэ жил алдагдалтай ажилласан боловч жилийн эхэнд үүнийг тооцоолсон байсан юм. Гишүүдийн харилцаа холбоог сайжруулах үүднээс вебсайтаа худалдан авсан үйлчилгээний зардал голлох хувийг эзэлсэн. Энэ нь зөвхөн нэг удаагийн зардал юм. Жилийн орлого нь ОУЗХ-ны ажилд хангалтгүй байдаг гэдэг нь тодорхой болсон. Тиймээс, 2014 оноос эхлэн төсвөө 3 жилийн хугацаатайгаар буюу Их Хурлаар олсон орлогоор өмнөх 2 жилийн алдагдлаа нөхөх боломж гарган батлахаар болсон. 3 дахь жилийн эцэст байгууллагын нөөцийг алдагдуулахгүй, мөн тэр улиралдаа олсон орлогоороо тэр үеийнхээ үйл ажиллагааг явуулах зорилготой байгаа билээ.

2013 оны жилийн эцсийн баланс

Үндсэн хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
ВМО-CDN данс		21556.43
ВМО-US данс		47828.43
Авлага		6756.22
Эргэлтийн хөрөнгийн дүн		76141.08
Валютын ханш		14.02
Нийт хөрөнгө		76155.10

Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч
Богино хугацаат өр төлбөр

	Ерөнхийлөгч Валерий Костин	
--	-------------------------------	--

Дансны өглөг	10985.00	Тэмдэглэл 1-г хар
Урьдчилж орсон гишүүнчлэлийн орлого		
2014	7838.37	
2015	3395.61	Тэмдэглэл 2-г хар
2016	435.37	
Богино хугацаат өр төлбөрийн дүн	22654.35	
Урт хугацаат өр төлбөр		
Билл Боукерийн тэтгэлэг	18872.57	Тэмдэглэл 3-г хар
Дружба фонд	1344.60	
Урт хугацаат үр төлбөрийн дүн	20217.17	
Нийт өр төлбөр	42871.52	
Эзэмшигчдийн өмч		
Өмнөх эздийн өмч	37256.58	
Цэвэр ашиг	-3973.00	
Эзэмшигчдийн өмчийн дүн	33283.58	
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	76155.10	

2013 оны жилийн эцсийн балансын тодруулга**Тэмдэглэл 1:** Дансны өглөг

2013 онд гарсан боловч оны сүүл гэхэд нэхэмжлэл нь ирж амжаагүй үйл ажиллагааны зардалыг энд тусгасан болно. Бүх төлбөрийг 2014 онд төлөх ч, зардалыг 2013 ондоо тусган тооцсон.

Тэмдэглэл 2: Урьдчилж орсон гишүүнчлэлийн орлого

Гишүүнчлэлийн төлбөрийг 3-н жилээр нь авдаг учираас нийт төлбөрийн гуравны нэгийг тэр жилдээ тусгана. Гишүүн хугацаанаасаа өмнө үйл ажиллагаагаа зогсоох тохиолдолд байгууллага төлбөрийг буцаан олгох хариуцлага хүлээдэг учир үүнийг өр төлбөрт хамааруулан бичнэ.

Тэмдэглэл 3: Билл Боукер тэтгэлэгийн фонд

Энэ фонд нь дотоод үйл ажиллагаанд зориулагдаагүй ба зөвхөн заагдсан шалгуур хангасан тохиолдолд хэрэглэнэ. 2013 онд Нигерийн “Ланлэйт Инициатив” нь бүх шаалгуур, заалтыг хангасан учир Билл Боукерын тэтгэлэгийн Зөвлөлийн зөвшөөрөлтэйгээр туслалцаа үзүүлсэн.

		ОУЗХ-г бүх зүйлд төлөөлнө		
		ТУЗ, жил бүрийн ерөнхий хуралдаан болон бусад захиргааны уулзалт буюу ЕГХУ, Ерөнхий Ассамблей зэргийг даргалан явуулна		
		Гүйцэтгэх удирдлагын хорооны хэлэлцүүлэгийг даргалан явуулах		
		Хэрэгтэй үед Зөвлөхүүдийн зөвлөлтэй хамтран ажиллах		
Өмнөх Ерөнхийлөгч	Сонгогдсон ерөнхийлөгч Жон Жоргенсон	Дэд ерөнхийлөгч Саэхико Танака	Ерөнхий нарийн бичиг Жон Жоргенсон	Санхүү Жилл Дандас
Хэрэгтэй үед Ерөнхийлөгч, ТУЗ-д зөвлөх хийх. Их Хурлаас хойш бүтэн нэг жилийн турш хашна	Их Хурал болохоос бүтэн нэг жилийн өмнө гэхэд сонгогдсон байна	ТУЗ-ийн зарим гишүүдийн өмнөөс нэмэлт хариуцлага хүлээнэ	Хурлын тэмдэглэлийг хөтлөн, бусдад тараах	Холбооны санхүүтэй холбоотой бүх үйл хэргийг хариуцна
Гүйцэтгэх болон ТУЗ-ийн бүх уулзалтад оролцох	Гүйцэтгэх болон ТУЗ-ийн бүх уулзалтад оролцох	ТУЗ-ийн бүх суудал дүүрсний дараа, тэд дундаас нэг хүнийг сонгох буюу томилно	Удирдлагуудад ирсэн бүх үйл хэргийг нягтлах	Санхүүгийн жилийн тайланг бэлтгэх
Зөвлөхүүдийн Зөвлөлд багтана /сонгуульгүй/	Зөвлөхүүдийн Зөвлөлд багтана /сонгуульгүй/	Гүйцэтгэх удирдлагын гишүүний үүднээс өдөр тутмын үйл хэрэгт оролцох	Хэрэгтэй үед Гүйцэтгэх удирдлагын зөвлөлийн хэлэлцүүлэгт оролцох	Хэрэгтэй үед Гүйцэтгэх удирдлагын зөвлөлийн хэлэлцүүлэгт оролцох
		Хэрэгтэй үед ерөнхийлөгчийг орлоно	Нийтэд гаргах жилийн тайланг бэлтгэх	Санхүүгийн тусалцаа хэрэгтэй зөвлөлд оролцох
Мэдээлэл харилцааны Карол Чели	Эрх бүхий гишүүн- Антон Денисов	Хөгжил дэвшил Фахреттин Гозет	Эрх бүхий гишүүн Фумио Морока	Удирдагч Элч Жеф Бредшоу
Вебсайт- Алина	Бүсийн тэнцвэртэй байдал хангаж, ТУЗ-д үзэл санаагаа хүргэх	Бренд бий болгох	Бүсийн тэнцвэртэй байдал хангаж, ТУЗ-д үзэл санаагаа хүргэх	Ерөнхий Ассамблейн уулзалт
Онлайн сонин- Жаки, Габриелла	Удирдах чадвартай байх, зөвлөлд хувь нэмрээ оруулах	Стратегийн түншлэл	Удирдах чадвартай байх, зөвлөлд хувь нэмрээ оруулах	ЕГХУ уулзалт
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Тусгай даалгавар, хөтөлбөр	Корпорацийн хамтрагчид	Тусгай даалгавар, хөтөлбөр	Элч нарын харилцаа холбоо
Бусад		Хандив босгох		Холбоотой харилцан ажиллах
Эрх бүхий гишүүн Түшиг Түвшин	Хөтөлбөр Дон Чели	Эрх бүхий гишүүн Алексиа Сидерис	Гишүүнчлэл Линда Пуллим	Их Хурал
Бүсийн тэнцвэртэй байдал хангаж, ТУЗ-д үзэл санаагаа хүргэх	Захирлуудын сургалт-Кони	Бүсийн тэнцвэртэй байдал хангаж, ТУЗ-д үзэл санаагаа хүргэх	Бүртгэл	Дараагийн хурал болох улс орныг сонгох
Удирдах чадвартай байх, зөвлөлд хувь нэмрээ оруулах	Шагнал	Удирдах чадвартай байх, зөвлөлд хувь нэмрээ оруулах	Гишүүдэд үйлчлэх	Их Хурал зохион байгуулах
Тусгай даалгавар, хөтөлбөр	Судалгаа	Тусгай даалгавар, хөтөлбөр	Харилцаа холбоо зохицуулах	Бусад арга хэмжээнд туслах
	ОУЗХ сургалтууд			
Зөвлөхүүдийн зөвлөл	Дотоод хамтрагчид	Элч нар Ерөнхий Ассамблей	Гадаад хамтрагчид	Холбоодуудын сүлжээ
Гүйцэтгэх удирдлагын өмнөх гишүүд	ОУЗХ харьяа бүлэг, байгууллагууд	Улс бүрээс жинхэнэ гишүүнчлэлтэй нэг элч сонгогдох эсвэл томилогдоно	Олон улсын зуслангууд	Гишүүн холбоодуудын ерөнхийлөгчид
Хүндэт гишүүд	Гүйцэтгэх зөвлөлтэй шууд холбоотой ажиллах	Ерөнхий Ассамблейн үед Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-д чиг өгөх, зөвлөх	Ижил төрлийн үйл ажиллагаатай, гишүүн бус байгууллагууд	Гишүүн холбоодуудын гүйцэтгэх нар
Гүйцэтгэх зөвлөлтэй шууд холбоотой ажиллах		ТУЗ-ийн тэнцвэртэй байдлыг хангах үүднээс Ерөнхий Ассамблейн үеэр 3-н эрх бүхий гишүүн сонгоно	Гүйцэтгэх зөвлөлтэй шууд холбоотой ажиллах	Их Хурлын болон бусал хэрэгтэй үеийн ЕГХУ

ОУЗХ-ны захиргаа





Pictures of Antalya, Turkey

For more information about ICC 2014, visit:
www.icc2014turkey.org/



Maritim Resort - Antalya, Turkey

For more information about ICF activities,
visit: www.campingfellowship.org